



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/705

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтын үйл ажиллагааны зардалд зориулан 1 100 000 төгрөгийг хавсралтад заасны дагуу зарцуулсугай.


2. Сургалтын үйл ажиллагааны зардал 1 100 000 төгрөг /нэг сая нэг зуун мянга/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 4.12 дахь заалт "Иргэдийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
11 дүгээр сарын 23-ны өдрийн  
А/705 дугаар захирамжийн хавсралт



### СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЦУУЛАЛТ

Д/д	Үйл ажиллагаа	Зарцуулах мөнгөн дүн /төгрөг/
1	Улаанбаатар-Ховд, Ховд-Улаанбаатар чиглэлд ирэх, очих онгоцны 2 талын зардал	740 000
2	Сургалтын үйл ажиллагааны зардал	360 000
Нийт		1 100 000

-оОо-